



КОРОНАВИРУС БА ЭДИЙН ЗАСАГ

12 сар



Улаанбаатар хот
2021.01.20

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Үндэсний Статистикийн хорооны улирал, сар, долоо хоногийн давтамжаар цуглуулдаг албан ёсны статистикийн мэдээллээр тус танилцуулгыг бэлтгэв.

Энэ удаагийн нийгэм, эдийн засгийн байдлын статистик мэдээллээр 2020 оны эцэст улсын хэмжээнд өмнөх оноос:


- ↓ Улсын нэгдсэн төсвийн орлого, тусламж 13.6%
- ↓ Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 6.7%
 - ↓ Уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл 8.4%
 - ↓ Боловсруулах салбарын үйлдвэрлэл 6.1%
- ↓ Экспорт 0.6%
- ↓ Импорт 13.6%
- ↓ Амьсгалын замаар дамжих халдварын тохиолдол 49.3%
- ↓ Гэмт хэрэг 26.8%-аар тус тус буурч,
- ↑ Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2.3%
- ↑ Улсын нэгдсэн төсвийн зарлага 19.7%
- ↑ Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 54.1%
- ↑ Нийгмийн халамжийн тэтгэмж 2.4 дахин өссөн байна.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ТАРХАЛТ


Монгол Улсад 2020 оны 3-12 дугаар сард коронавирусын нийт 1215 тохиолдол бүртгэгдсэний 830 (68.3%) нь эдгэрсэн байна. Нийт тохиолдлын 399 (32.8%) нь зөөвөрлөгдсөн, 816 (67.2%) нь дотоодод тархсан халдвар байна.

Зураг 2. Коронавирусын тохиолдлын тоо, сараар, 2020 он



Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Зураг 1. Коронавирусын тохиолдлын тоо, насны бүлэг, хүйсээр, 2020 он



Коронавирусын нийт тохиолдлын 614 (50.5%) нь эрэгтэй, 601 (49.5%) нь эмэгтэй байна. Насны бүлгээр харвал 20-44 насныхан 626 (51.5%), 45-аас дээш насныхан 339 (27.9%), 0-19 насныхан 250 (20.6%) байна.

Харин 12 дугаар сард коронавирусын 16 зөөвөрлөгдсөн, 408 дотоодод тархсан халдвар, нийт 424 тохиолдол илэрсэн байна.

Энэ оны эхнээс коронавируст халдвар дэгдсэнтэй холбоотойгоор хөл хорио тогтоон иргэдийг олон нийтийн газраар явахгүй байж, гараа тогтмол угааж, маск зүүхийг зөвлөж байсны нөлөөгөөр ханиад, томуугийн дэгдэлт өнгөрсөн онуудаас эрс багасаж, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо буураад байна.

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид 2020 онд сард 836.3 мянга болж, өмнөх оноос 91.0 (9.8%) мянган хүнээр буурсан байна.

Хүснэгт 1. Халдварт өвчин, төрлөөр, жил бүрийн эхний 11 сарын байдлаар

Үзүүлэлт	2019	2020	$\frac{2020}{2019}$ %	
Халдварт өвчнөөр өвчлөгчид	45 232	33 376	73.8	Халдварт өвчнөөр өвчлөгчид 2020 онд 33.4 мянга болж, өмнөх оноос 11.9 мянга (26.2%)-аар буурсан байна.
Цусаар дамжих	527	353	67.0	
Вируст гепатит	527	353	67.0	Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварын замын төрлөөр авч үзэхэд
Амьсгалын замаар дамжих	16 423	8 319	50.7	2020 оны 12 дугаар сард бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол 970 болж, өмнөх сараас 60 (5.8%)-аар, цусаар дамжих халдварын тохиолдол 22 болж, 5 (18.5%)-аар, гэдэсний халдварт өвчин 40 болж, 52 (56.5%)-оор, амьсгалын замаар дамжих халдварын тохиолдол 306 болж, 973 (76.1%)-аар буурсан байна.
Сүрьеэ	3 624	3 339	92.1	
Салхин цэцэг	10 652	2 883	27.1	
Гар, хөл, амны өвчин	2 147	2 097	97.7	
Гэдэсний халдварт	5 438	2 630	48.4	
Цусан суулга	5 438	2 630	48.4	
Бэлгийн замаар дамжих	17 865	16 157	90.4	
Тэмбүү	7 095	6 555	92.4	
Гонкоккт халдвар	5 772	5 131	88.9	
Трихомониаз	4 980	4 446	89.3	
ХДХВ/ДОХ	18	25	138.9	
Бусад	1 917	4 607	2.4 ¹	
Мөөгөнцөр	1 917	3 392	1.8 ¹	
Коронавируст халдвар	-	1 215	-	

¹ дахин их

Эх үүсвэр: УСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12


ГЭМТ ХЭРЭГ

Коронавируст халдварын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон хөл хорио нь гэмт хэргийн гаралт буурахад эергээр нөлөөлж байна. Гэвч нөгөө талдаа гэр бүлийн хүчирхийллийн зөрчил нэмэгдэх шалтгаан болж байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 онд 23.1 мянга болж, өмнөх оноос 8460 (26.8%)-аар, харин 2020 оны 12 дугаар сард 1440 болж, өмнөх сараас 860 (37.4%)-аар тус тус буурсан байна.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 онд улсын дунджаар 108 болж, өмнөх оноос 38 (26.0%)-аар буурсан байна.

Зураг 3. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Эх үүсвэр: УСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2020 онд 111 бүртгэгдсэн нь өмнөх оноос 96 (46.4%)-гаар буурсан байна. Харин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэрэг 2020 оны 12 дугаар сард 12 бүртгэгдсэн нь өмнөх сараас 2 (14.3%)-оор буурсан байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2020 онд 10306 зөрчил бүртгэгдсэний 8451 (82.0%) зөрчлийг шалган шийдвэрлэсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт зөрчил өмнөх оноос 1344 (15.0%)-өөр, шийдвэрлэсэн зөрчил 1817 (27.4%)-гоор тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2020 онд 255.0 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 82.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 92.6 (57.0%) тэрбум төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 38.3 (87.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2020 онд 23.1 мянга болж, 1181 (5.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 9.4 (40.9%) мянга нь эмэгтэйчүүд байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн сангаас 2020 онд 2.6 (давхардсан тоогоор) сая хүнд 1.6 их наяд төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгосон нь өмнөх оноос нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 194.6 (8.2%) мянгаар, үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 912.5 (2.4 дахин) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, тэдгээрт олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ, төрлөөр

Үйлчилгээний төрөл	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид		Халамжийн үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт	
	мянган хүн	Жилийн өсөлтийн хувь	сая төгрөг	Жилийн өсөлтийн хувь
Бүгд	2 553 972	8.2	1 581 975.8	2.4 ¹
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	429 821	-0.4	316 043.1	39.1
Нийгмийн халамжийн тэтгэвэр	59 110	-2.6	162 825.9	45.9
Нийгмийн халамжийн тэтгэмж	121 728	1.3	99 008.9	26.9
Нийгмийн халамжийн үйлчилгээ	64 320	1.4	58 429.8	22.6
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ (Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ)	57 408	1.2	40 579.1	33.6
Эхийн алдар одонгийн мөнгөн урамшуулал	6 995	-16.8	1 687.5	-7.4
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	241 988	-0.1	52 520.8	47.0
Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	230 189	2.7	29 708.0	1.7
Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	1 186 289	18.6	1 053 045.8	358.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	236 718	21.7	28 305.2	-7.1
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	2 518	-8.6	5 124.9	0.2
Насны хишиг	38 420	-33.7	10 737.7	-6.4
Цаатан иргэний тэтгэмж	287 855	-7.9	115 531.2	1.2

¹ дахин их

Нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өсөхөд Засгийн газраас иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр иргэдэд олгож буй тэтгэмж нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Үүнд:

- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 80.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 100.0 мянган төгрөг (Хэрэгжих хугацаа: 2020.04.01-12.31)

- Нийгмийн халамжийн сангаас олгож буй халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 288.0 мянган төгрөг (Хэрэгжих хугацаа: 2020.05.01-12.31),
- Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүнд олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийн үнийн дүнг 2 дахин (Хэрэгжих хугацаа: 2020.05.01-12.31).

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2020 онд 59.1 мянган хүн хамрагдсан нь өмнөх оноос 1.5 мянган (2.6%) хүнээр буурч, олгосон тэтгэврийн хэмжээ 51.5 (45.9%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн 67.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, олгосон тэтгэврийн хэмжээ 108.5 тэрбум төгрөг, 26.1 хувь нь тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, олгосон тэтгэврийн хэмжээ 44.4 тэрбум төгрөг, 6.4 хувь нь ахмад настан, олгосон тэтгэврийн хэмжээ 9.6 тэрбум төгрөг байна.


Нийгмийн халамжийн тэтгэмжид 2020 онд 121.7 мянган хүн хамрагдаж, нийт 99.0 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оноос 21.0 (26.9%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Үүнд, асаргааны тэтгэмжид 64.3 мянган хүн хамрагдаж, олгосон тэтгэмж 58.4 тэрбум төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжид 57.4 мянган хүн хамрагдаж, олгосон тэтгэмж 40.6 тэрбум төгрөг болов.

18 хүртэлх насны 1.2 сая хүүхдэд 1.1 их наяд төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2020 онд олгожээ.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэдийн тоо 2020 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар 30.0 мянга болжээ. Үүнээс 18.1 (60.4%) мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 11.9 (39.6%) мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 9.5 (52.7%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Зураг 4. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй ажилгүй иргэд, сараар



Эх үүсвэр: УСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа нэгжүүд хэвийн ажиллаж байна. Гэвч хөл хорионы дэглэмээс шалтгаалж аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа алдагдах, мөн ихэнх иргэд биечлэн очиж үйлчлүүлэх боломжгүй зэргээс ажил хайгч иргэдийн тоо буурсаар байна. Энэхүү нийгмийн байдал нь нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо буурахад нөлөөж өмнөх оны мөн үеэс 2.7 (12.8%) мянган хүнээр, өмнөх сараас 484 (2.6%) хүнээр буурчээ.

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2020 оны 12 дугаар сард ажилгүй 5.8 мянган иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 2.3 мянган иргэн ажилд зуучлагдан орж, 3.9 мянган иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Үүнээс Улаанбаатар хотод 2020 оны 12 дугаар сард нийт 1.6 мянган иргэн нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 716 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Шинээр ажил хайж байгаа иргэдийн тоо буурч байгаа нь иргэдийн ажил хайх идэвх суларч байгааг харуулж байна.

Бүртгэлтэй ажилгүй гурван хүн тутмын нэг нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой байна.

Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 53.9 хувийг 15-34 насны залуучууд эзэлж, энэ үзүүлэлт Сэлэнгэ, Өвөрхангай, Увс, Ховд, Говьсүмбэр, Өмнөговь, Дорнод аймагт улсын дунджаас 1.9-30.8 пунктээр дээгүүр байна

УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 10.4 их наяд төгрөг болж өмнөх оноос 13.6 хувиар буурсан байна. Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 9.4 их наяд төгрөг болж нийт орлогын 90.6 хувийг эзэлж байна.

Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 14.0 их наяд төгрөг болж өмнөх оноос 2.3 их наяд төгрөгөөр (19.7%) өсөж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 4.5 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.

Хүснэгт 3. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, 2020 он


Хугацаа	Нийт орлого, тусламжийн хэмжээ	Тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ	Нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ	Тэнцвэржүүлсэн тэнцэл (+,-)
	тэрбум төгрөг			
2020* I	767.7	708.4	641.3	67.2
II	696.7	660.8	848.0	- 187.1
III	760.2	704.5	860.5	- 156.0
IV	642.4	603.0	970.5	- 367.5
V	697.0	666.7	1 602.0	- 935.3
VI	794.7	756.9	1 376.0	- 619.2
VII	902.8	800.0	1 067.6	- 267.6
VIII	822.7	799.1	990.1	- 190.9
IX	1 232.4	1 002.0	1 084.8	- 82.7
X	940.3	854.9	1 374.6	- 519.7
XI	811.3	694.4	1 146.5	- 452.1
XII	1 333.7	1 170.9	1 998.9	- 828.0
I-XII	10 402.0	9 421.6	13 960.8	- 4 539.1

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ 2020 оны 12 дугаар сард 1.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 476.5 (68.6%) тэрбум төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 852.4 (74.3%) тэрбум төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 828.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 375.9 (83.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлого буурсан нь орлогын 81.7 хувийг бүрдүүлсэн татварын орлого буурсантай холбоотой.

Татварын нийт орлого 2020 онд 8.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.3 (13.4%) их наяд төгрөгөөр буурахад нийгмийн даатгалын орлого 442.5 (21.8%) тэрбум төгрөг, орлогын албан татвар 335.8 (13.1%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 281.0 (11.3%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 117.0 (12.8%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 86.5 (10.0%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 49.4 (6.3%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Зураг 5. Улсын нэгдсэн төсвийн татварын орлогын бүтэц, дүнд эзлэх хувиар



Татварын орлогод 2020 онд орлогын албан татвар 26.1 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 26.0 хувь, нийгмийн даатгалын орлого 18.7 хувь, бусад татвар 11.4 хувь, онцгой албан татвар 9.1 хувь, гадаад үйл ажиллагааны орлого 8.7 хувийг эзэлж байна.

Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Татварын нийт орлогод нийгмийн даатгалын орлогын эзлэх хувь өмнөх оноос 2.0 пунктээр буурч, нэмэгдсэн өртгийн албан татварынх 0.7 пункт, гадаад үйл ажиллагааны орлогынх 0.6 пункт, бусад

татварын эзлэх хувь 0.3 пункт, онцгой албан татварынх 0.3 пункт, орлогын албан татварын эзлэх хувь 0.1 пунктээр тус тус өссөн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2020 онд 14.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 2.3 (19.7%) их наяд төгрөгөөр өссөн байна. Зарлагын өсөлтөд урсгал зардал 2.6 (32.1%) их наяд төгрөг, хөрөнгийн зардал 35.0 (1.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Харин эргэж төлөгдөх цэвэр зээл 378.9 (91.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Улсын нэгдсэн төсвийн зарлага, цэвэр зээл, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2017	2018	2019	2020*	$\frac{2020^*}{2019}$ %
Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ	9 017.3	9 222.9	11 661.7	13 960.8	119.7
Нийт зарлага	8 701.3	8 955.8	11 245.3	13 923.2	123.8
Урсгал зардал	7 043.2	7 348.0	8 228.6	10 871.6	132.1
Бараа, ажил үйлчилгээний зардал	3 141.4	3 316.4	4 000.5	4 875.5	121.9
Хүү	1 156.5	1 046.9	861.0	959.4	111.4
Татаас	260.6	228.2	298.9	374.2	125.2
Урсгал шилжүүлэг	2 484.6	2 756.6	3 068.2	4 662.5	152.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	22.0	82.0	82.4	182.6	2.2 ¹
Бусад урсгал шилжүүлэг	2 462.7	2 674.6	2 985.8	4 479.9	150.0
Хөрөнгийн зардал	1 658.1	1 607.8	3 016.7	3 051.7	101.2
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	316.0	267.1	416.4	37.6	9.0
Эргэж төлөгдөх цэвэр зээл	200.8	177.3	278.6	- 97.9	-
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	115.2	89.9	137.8	135.4	98.3

¹ Дахин их

Эх үүсвэр: УСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Урсгал зардалд бараа үйлчилгээний зардал 2020 онд 44.9 хувь, урсгал шилжүүлэг 42.9 хувь, хүүгийн зардал 8.8 хувь, татаас 3.4 хувийг эзэлж байна.

Хөрөнгийн зардалд 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 3.1 их наяд төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 35.0 (1.2%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Хөрөнгийн зардал өсөхөд барилга, байгууламжийн зардал 338.0 (15.0%) тэрбум төгрөг, их засварын зардал 18.2 (11.3%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч тоног төхөөрөмжийн зардал 193.3 (79.3%) тэрбум төгрөг, бусад хөрөнгийн зардал 197.7 (59.1 %) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн 4.5 их наяд төгрөгийн алдагдлын санхүүжилтийг эх үүсвэрээр харвал харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлтөөр 2.1 их наяд төгрөгийг, ЗГ-ын гадаад зээлээр 2.7 их наяд төгрөгийг санхүүжүүлсэн байна.

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр ЗГ-ын гадаад зээлийн санхүүжилт өмнөх оноос 2.4 дахин өссөн байна.

Хүснэгт 5. Улсын нэгдсэн төсвийн алдагдлын санхүүжилт, жил бүрийн эхний 11 сарын байдлаар

Эх үүсвэр	2017	2018	2019	2020*	$\frac{2020^*}{2019}$
	тэрбум төгрөг				хувь
АЛДАГДЛЫН САНХҮҮЖИЛТ, ЭХ ҮҮСВЭРЭЭР	1 742.5	-3.0	756.2	4 539.1	6.0¹
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-1 013.2	631.3	-1 103.4	2 142.6	-
Засгийн газрын бонд	206.6	-2 434.7	-165.1	-249.4	159.3
Дотоод	-2 305.7	-1 767.7	-165.1	-263.0	159.3
Гадаад	2 512.3	-667.0	0.0	13.6	
Засгийн газрын зээл	1 794.7	1 568.3	1 651.6	2 481.5	120.4
Дотоод	-269.6	408.7	466.3	-186.0	-
Гадаад	2 064.3	1 159.5	1 185.3	2 667.5	2.4 ¹
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	160.0	100.0	50.0	0.0	-
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	572.1	122.7	322.0	138.8	-
Өмч хувьчлал	22.2	9.4	1.0	25.7	44.4 ¹


¹ Дахин их

НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалд 2020 онд 1.2 сая хүн даатгуулсны 83.4 хувь нь албан журмаар, 16.6 хувь нь сайн дураар даатгуулсан байна. Албан журмаар даатгуулагсдын 70.2 хувь (нийт даатгуулагчдын 58.5 хувь) нь аж ахуй нэгж байгууллагынх байгаа бол 29.8 хувь (нийт даатгуулагсдын 24.9 хувь) нь төсөвт байгууллагын ажиллагсад байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2020 онд 2.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 134.2 (4.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оноос 134.2 тэрбум төгрөгөөр буурахад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин (ҮОМШӨ)-ий даатгалын сангийн орлого 71.3 (33.3%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 6. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар



Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2020 онд 3.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 703.0 (28.0%) тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 337.9 (18.4%) тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 355.0 (4.1 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

ААНБ, ИРГЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 12 дугаар сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 205.7 (1.2%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оноос 889.2 (4.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.7 (50.6%) их наяд төгрөг нь иргэдийнх байна.

Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 12 дугаар сарын эцэст 13.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 118.8 (0.9%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оноос 1.5 (9.8%) их наяд төгрөгөөр буурчээ. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 80.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 4.4 пунктээр буурсан байна.

Хүснэгт 6. Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, зээлийн ангиллаар, сар бүрийн эцэст


	2019		2020*		2020*XII	2020*XII
	XI	XII	XI	XII	2019 XII	2020*XI
	тэрбум төгрөг				хувь	
Зээлийн өрийн үлдэгдэл	18 168.7	18 096.1	17 001.2	17 206.9	95.1	101.2
Хэвийн зээл	15 282.3	15 447.0	13 809.1	13 927.9	90.2	100.9
Хугацаа хэтэрсэн зээл	968.5	824.0	1 179.4	1 269.4	154.1	107.6
Чанаргүй зээл	1 918.0	1 825.1	2 012.7	2 009.6	110.1	99.8

Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 12 дугаар сарын эцэст 1.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 90.0 (7.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 445.4 (54.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.4 хувийг эзэлж, өмнөх оноос 2.8 пунктээр өссөн байна.

Чанаргүй зээл 2020 оны 12 дугаар сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 3.1 (0.2%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оноос 184.5 (10.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.7 хувийг эзэлж, өмнөх оноос 1.6 пунктээр өссөн байна.

Зураг 7. Чанаргүй зээл, сар бүрийн эцэст, тэрбум төгрөг



Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Арилжааны банкуудаас иргэдэд олгосон зээл 2020 оны 11 дүгээр сарын эцэст 8.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 173.6 (2.0%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 701.2 (7.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Иргэдэд олгосон зээлийн 43.8 хувийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх зээл, 33.1 хувийг цалингийн зээл, 8.6 хувийг малчны зээл, 6.0 хувийг хадгаламж, данс барьцаалсан зээл, 2.9 хувийг автомашины зээл, 2.7 хувийг картын зээл, 0.8 хувийг өрхийн хэрэглээний зээл, 0.7 хувийг тэтгэврийн зээл, 1.4 хувийг бусад зээл тус тус эзэлж байна.

Хүснэгт 7. Арилжааны банкуудаас иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлт, сарын эцэст

	2019 XI	2020		2020* XI
		X	XI	2020*X
	сая төгрөг			
Иргэдийн зээлийн эргэн төлөлт	788 882.4	971 478.8	733 509.9	75.5
Эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх зээл	180 852.9	342 431.1	236 844.9	69.2
Цалингийн зээл	199 695.9	173 953.0	135 499.5	77.9
Тэтгэврийн зээл	-	29 918.9	23 515.4	78.6
Картын зээл	121 050.8	111 676.1	85 603.9	76.7
Автомашины зээл	10 081.1	11 818.0	6 812.5	57.6
Өрхийн хэрэглээнд зориулсан зээл	-	6 418.6	4 847.0	75.5
Сургалтын зээл (гадаад)	-	2.9	2.2	77.3
Малчны зээл	-	54 133.5	55 744.9	103.0
Хадгаламж, данс барьцаалсан зээл	209 755.3	235 214.8	180 440.6	76.7
Бусад	67 446.3	5 912.0	4 199.1	71.0

Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Арилжааны банкуудаас иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлт 2020 оны 11 дүгээр сарын эцэст 733.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 238.0 (24.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 55.4 (7.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зээлийн эргэн төлөлтийн 32.3 хувийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх зээл, 24.6 хувийг хадгаламж, данс барьцаалсан зээл, 18.5 хувийг цалингийн зээл, 11.7 хувийг картын зээл, 7.6 хувийг малчны зээл, 3.2 хувийг тэтгэврийн зээл, 0.9 хувийг автомашины зээл, 0.7 хувийг өрхийн хэрэглээнд суурилсан зээл, 0.6 хувийг бусад төрлийн зээл тус тус эзэлж байна.

Жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээл 2020 оны 11 дүгээр сарын эцэст 3.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 36.1 (1.0%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 472.5 (11.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар нь авч үзвэл, 27.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 12.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 11.8 хувь нь барилга, 5.5 хувь нь байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа, 4.3 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын, 38.8 хувь нь бусад салбарынх байна.

Хүснэгт 8. Иргэдэд олгосон ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл, сарын эцэст

	2019 XI	2020*		2020* XI	2020* XI
		X	XI	2019 XI	2020* X
Иргэдэд олгосон ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр	4 574.3	4 867.1	4 870.0	106.5	100.1
Иргэдэд олгосон ипотекийн зээлдэгчдийн тоо, мянган хүнээр	95.9	99.9	100.0	104.3	100.1

Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Арилжааны банкнууд болон Монголын Ипотекийн корпорац (МИК)-аас иргэдэд олгосон ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 11 дүгээр сарын эцэст 4.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 2.9 (0.06%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 295.7 (6.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкууд орон сууцны ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах хүсэлтийг цахим хэлбэрээр авч эхэлсэн өдрөөс хойш 2020 оны арванхоёрдугаар сарын 18-ний өдрийн байдлаар нийт 47621 хүсэлтийг хүлээн авч, 44443 хүсэлтийг буюу 93 орчим хувийг нь шийдвэрлэж эргэн төлөлтийг хойшлуулжээ. Үүний зээлийн үлдэгдэл нь 2.4 их наяд орчим төгрөг буюу нийт ипотекийн зээлийн багцын үлдэгдлийн 66 орчим хувийг эзэлж байна.

ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш 2020 оны 12 дугаар сард 2849.55 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар суларч, өмнөх сараас 0.02 хувиар чангарсан байна.

Төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2020 оны 12 дугаар сард 435.64 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар, өмнөх сараас 1.0 хувиар, төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 2020 оны 12 дугаар сард 38.42 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар чангарч, өмнөх сараас 3.8 хувиар тус тус суларсан байна.

Хүснэгт 9. Монголбанкнаас зарласан төгрөгийн гадаад валюттай харьцах сарын дундаж ханш, төгрөгөөр


Үзүүлэлт	2017 XII	2018 XII	2019 XII	2020 XII
Америк доллар	2 433.49	2 637.35	2 727.34	2 849.55
Жилийн өөрчлөлт, хувиар	-2.0	8.4	3.4	4.5
Сарын өөрчлөлт, хувиар	-0.6	2.1	0.8	-0.02
Евро	2 879.43	3 002.43	3 030.51	3 466.18
Жилийн өөрчлөлт, хувиар	9.9	4.3	0.9	14.4
Сарын өөрчлөлт, хувиар	0.2	2.3	1.3	2.9
Юань	369.00	383.03	388.75	435.64
Жилийн өөрчлөлт, хувиар	2.9	3.8	1.5	12.1
Сарын өөрчлөлт, хувиар	-0.2	3.0	0.9	1.0
Рубль	41.52	39.15	43.38	38.42
Жилийн өөрчлөлт, хувиар	3.8	-5.7	10.8	-11.4
Сарын өөрчлөлт, хувиар	-0.1	0.6	2.4	3.8

Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

ИНФЛЯЦ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 12 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оноос 2.3 хувиар өсөж, өмнөх сараас 0.6 хувиар буурсан байна.

Зураг 8. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Эх үүсвэр: УСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.11


Инфляцын түвшин 2017 оны 12 дугаар сард 6.4 хувь, 2018 оны 12 дугаар сард 8.1 хувь, 2019 оны 12 дугаар сард 5.2 хувь гарч байсан бол 2020 оны 12 дугаар сард 2.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.9 пунктээр буурсан байна.

Инфляц төв банкны зорилтод түвшнээс (8%) буурч байгаа нь эдийн засгийн идэвх суларсныг илтгэж байна.

Инфляцын түвшин 2020 оны 12 дугаар сард улсын хэмжээнд 2.3 хувь гарсны 2.2 нэгж буюу 95.7 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 2019 оны 12 дугаар сард 7.6 хувиар, 2020 оны 12 дугаар сард 7.9 хувиар өсөж, өсөлтийн хурдац 0.3 пунктээр нэмэгдэж, хүнсний бус бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2019 оны 12 дугаар сард 4.3 хувиар өсөж, 2020 оны 12 дугаар сард 0.1 хувиар буурч, өсөлтийн хурдац 4.4 пунктээр буурчээ.


Зураг 9. Хүнс, хүнсний бус бүлгийн үнийн индекс, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар



Эх үүсвэр: УСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.11

Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2020 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 9.7 хувиар өсөхөд үхрийн махны үнэ 9.7 хувь, хонины ястай махны үнэ 12.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.


Зураг 10. Мах, махан бүтээгдэхүүний үнийн индекс (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувь, сараар



Эх үүсвэр: УСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 2019 оны 12 дугаар сард 4.8 хувиар, 2020 оны 12 дугаар сард 2.6 хувиар өсөж, өсөлтийн хурдац 2.2 пунктээр, үйлчилгээний бүлгийн үнэ 2019 оны 12 дугаар сард 6.6 хувиар, 2020 оны 12 дугаар сард 1.4 хувиар өсөж, өсөлтийн хурдац 5.2 пунктээр тус тус бүүрсан байна.

Зураг 11. Бараа, үйлчилгээний бүлгийн үнийн индекс, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар



Үнийн судалгааны сагс дахь нийт 373 нэр төрлийн бараа, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байдаг бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлдэг.

Инфляц 2020 оны 12 дугаар сард 2.3 хувь гарсны 39.1 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 4.5 пунктээр өссөн.

Хүснэгт 10. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 10 дугаар сард


Үзүүлэлт	2018 XII		2019 XII		2020 XII	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
Ерөнхий индекс	8.1	100.0	5.2	100.0	2.3	100.0
Импортын барааны нөлөө	2.9	35.8	1.8	34.6	0.9	39.1

Эх үүсвэр: УСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.11

ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 онд урьдчилсан гүйцэтгэлээр 16.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.2 (6.7%) их наяд төгрөгөөр буурлаа. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.1 (8.4%) их наяд төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 227.6 (6.1%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна. Харин цахилгаан хий, уур, агааржуулалтын салбарын үйлдвэрлэл 74.9 (6.7%) тэрбум төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэл 23.6 (21.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 12. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл, салбараар, сараар, тэрбум төгрөг
2 000.0



Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 онд урьдчилсан гүйцэтгэлээр 11.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.1 (8.4%) их наяд төгрөгөөр буурахад нүүрс олборлолт 1.5 (28.5%) их наяд төгрөгөөр, газрын тос олборлолт 584.8 (57.0%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 2020 онд урьдчилсан гүйцэтгэлээр зэсийн баяжмал, металл агуулгаараа, төмрийн хүдэр болон алтны олборлолт өмнөх оноос 1.1-24.6 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт ус, ундаа, шүүс, цемент, гурил, шингэн сүү зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.8-11.5 хувиар тус тус өссөн байна. Мөн нүүрсэн шахмал түлш болон амны хаалтын үйлдвэрлэл 2020 онд өмнөх оноос 2.7-13.3 дахин өссөн байна.

Харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хүрэн нүүрс, хайлуур жонш, чулуун нүүрс, газрын тос зэрэг бүтээгдэхүүний олборлолт өмнөх оноос 1.8-40.3 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт спирт, согтууруулах ундаа, шохой, катодын зэс, ноолууран сүлжмэл эдлэл, малын мах, баяжуулсан нүүрс, самнасан ноолуур, металл бэлдэц, тамхи зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.8-49.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 11. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, дэд салбараар

Дэд салбар	2020*							
	X	XI	XII	I-XII	X	XI	XII	I-XII
	тэрбум төгрөг				өмнөх оны мөн үетэй харьцуулахад, хувиар			
Боловсруулах үйлдвэрлэл	376.1	293.9	316.8	3 522.0	112.9	86.8	99.4	93.9
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	105.4	107.1	121.9	985.6	114.1	96.4	107.6	104.9
Мах боловсруулах, консервлох	40.2	28.2	36.6	262.5	136.5	58.5	87.7	93.5
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	2.1	4.5	5.4	31.4	80.1	195.5	213.4	141.0
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	18.5	20.2	21.2	209.6	96.6	108.3	104.5	99.1
Үр тарианы гурилын болон цардуул, цардууллаг	22.5	33.7	32.1	246.3	104.4	155.5	129.0	119.1
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл	22.2	20.5	26.6	235.9	112.7	100.8	111.4	107.8
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	70.2	47.1	42.2	694.4	126.1	87.6	71.6	100.8
Ундаа үйлдвэрлэл	4.4	0.9	5.0	39.3	144.7	55.4	502.7	2.01
Тамхи үйлдвэрлэл	27.1	8.0	14.3	381.8	65.2	24.7	39.4	60.1
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	6.5	3.3	2.8	68.8	56.8	26.4	27.2	54.6
Хувцас үйлдвэрлэл	2.9	1.1	3.4	31.7	146.2	79.7	99.8	143.8
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.7	0.2	0.4	7.8	190.0	73.1	62.3	111.8
Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл; сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл	3.7	3.3	3.4	42.0	117.1	103.1	87.1	122.6
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4.4	2.3	2.3	46.0	83.9	59.0	54.1	96.9
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	78.3	76.7	82.7	546.8	161.2	120.8	209.2	106.8
Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8.5	9.4	10.9	91.5	96.3	98.3	154.8	83.9
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3.4	3.7	5.7	50.7	149.2	155.0	149.6	147.8
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	1.5	0.8	1.7	14.1	81.5	70.5	124.2	86.3
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	30.9	13.6	3.7	251.7	89.8	66.3	39.9	93.4
Төмөрлөг бүс эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	23.5	13.8	13.2	225.2	135.1	84.0	60.2	96.2
Металл боловсруулах үйлдвэрлэл	0.2	0.1	0.2	2.8	38.8	39.8	72.9	36.6
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.4	0.3	0.4	4.5	191.7	80.8	108.7	125.3
Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл	1.5	0.5	0.5	13.9	77.8	35.4	36.0	77.6
Тавилга үйлдвэрлэл	2.5	1.8	2.3	23.4	103.9	55.5	129.7	93.9

¹дахин их

Эх үүсвэр: YCX, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудаас Ковид-19 цар тахлын нөлөөнд хамгийн ихээр өтгөж буй ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх онтой харьцуулахад 39.9 хувь, хувцас үйлдвэрлэл 45.4 хувь, машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл 63.4 хувь тус тус буурсан байна.

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оноос сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл өссөн бол үхэр, хорь, адууны мах үйлдвэрлэл 20.2-34.2 хувиар буурсан байна.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хувьд 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр хиам, сүү, тараг, иогурт, цөцгийн тос зэрэг 21 бүтээгдэхүүний үйлдвэрлэл өмнөх оноос өссөн бол бууз, банш,

хуушуур, хонины мах, чипс, жигнэмэг, гоймон, үхрийн мах үйлдвэрлэл зэрэг 15 бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан байна.

Хүснэгт 12. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2019		2020*		2020* I-XII / 2019 I-XII %
		XII	I-XII	XII	I-XII	
Үхрийн мах, сэврээсэн мах	т	802.2	3 827.5	488.5	2 620.2	68.5
Хонины мах, сэврээсэн мах	т	1 124.5	8 392.9	903.4	6 701.2	79.8
Адууны мах, сэврээсэн мах	т	2 682.8	16 147.2	908.5	10 618.3	65.8
Ямааны мах, сэврээсэн мах	т	1 211.4	3 560.5	1 253.3	3 930.6	110.4
Өлөн гэдэс	мян.гогцоо	76.7	704.0	97.2	577.6	82.1
Хиаман төрлийн бүтээгдэхүүн	т	542.1	5 772.0	841.7	6 633.6	114.9
Боловсруулсан шингэн сүү	мян.л	4 225.3	40 387.2	4 809.9	45 044.1	111.5
Тараг, йогурт	мян.л	1 248.3	13 722.9	1 705.3	15 937.8	116.1
Зайрмаг, болон зайрмаган бүтээгдэхүүн	мян.ш	3 608.3	104 766.6	2 995.9	103 257.9	98.6
Шинэ цөцгий	т	0.3	3.6	0.1	5.6	156.7
Цөцгийн тос	т	15.3	203.9	44.4	250.2	122.7
Өтгөн цөцгий	т	26.0	175.7	3.7	178.7	101.7
Өрөм, зөөхий	т	43.3	530.5	62.2	574.4	108.3
Шар тос	т	1.8	131.5	0.3	16.6	12.6
Улаан буудайн дээд гурил	т	5 960.5	48 752.9	5 489.7	51 612.4	105.9
Буудайн I зэргийн гурил	т	20 612.3	145 308.4	20 529.3	159 086.0	109.5
Буудайн II зэргийн гурил	т	2 942.8	17 546.2	1 718.1	24 415.7	139.2
Багсармал тэжээл, хивэг	т	10 442.4	75 993.2	11 653.7	87 970.4	115.8
Талх	т	2 476.3	27 798.7	3 276.7	29 851.5	107.4
Нарийн боов	т	1 973.3	21 855.5	2 641.2	25 889.9	118.5
Бялуу	т	389.8	2 469.8	480.3	2 755.1	111.6
Чихэр	т	3.4	45.5	1.3	34.4	75.6
Амтат жигнэмэг, өрмөнцөр	т	240.7	1 465.6	75.5	883.1	60.3
Гоймон	т	884.0	8 842.7	111.2	4 615.8	52.2
Пүнтүүз	т	4.3	48.3	6.6	59.1	122.4
Банш, бууз хуушуур	т	518.9	5 171.5	315.7	4 260.6	82.4
Савласан ногоон цай	кг	18 003.3	130 339.2	20 398.0	181 201.7	139.0
Шарсан төмс /чипс/	т	204.7	1 723.9	58.4	1 059.9	61.5
Өндөг	мян.ш	452.1	63 509.5	9 225.4	82 132.5	129.3
Цэвэр спирт	мян.л	593.6	10 143.1	375.2	10 063.7	99.2
Цагаан архи	мян.л	2 697.2	26 874.0	1 098.3	24 350.8	90.6
Оргилуун дарснаас бусад төрлийн усан үзмийн дарс	мян.л	73.9	281.5	85.5	300.2	106.7
Соёолжоор бэлтгэсэн шар айраг	мян.л	7 785.9	91 975.1	5 900.8	92 802.2	100.9
Цэвэр ус	мян.л	6 805.0	98 640.5	4 328.0	74 568.5	75.6
Амтат ус, ундаа	мян.л	14 568.7	174 894.6	14 644.4	204 146.7	116.7
Жүүс	мян.л	3 010.7	41 939.7	3 060.3	39 405.3	94.0

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2020 онд урьдчилсан гүйцэтгэлээр 19.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 902.3 (4.4%) тэрбум төгрөгөөр буурлаа. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 539.2 (3.8%) тэрбум төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын борлуулалт 470.6 (8.8%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 13. Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн, салбараар, жил бүрийн эцсийн байдлаар

Салбар	2019		2020*			2020* I-XII
	XII	I-XII	XII	I-XII	гадаадад	2019 I-XII
	тэрбум төгрөг					хувь
Нийт дүн	1 802.0	20 639.9	2 285.8	19 737.6	11 735.4	95.6
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1 140.5	14 033.4	1 709.8	13 494.2	10 022.7	96.2
Боловсруулах аж үйлдвэр	529.0	5 372.9	432.8	4 902.3	1 712.7	91.2
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	123.0	1 123.9	129.6	1 200.8	-	106.8
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	9.5	109.8	13.5	140.4	-	127.9

Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Нийт борлуулсан бүтээгдэхүүний 11.7 их наяд төгрөг буюу 59.5 хувийг гадаад зах зээлд борлуулжээ. Гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний 10.0 их наяд төгрөг буюу 85.4 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн эзэлж байна. Гадаад зах зээлд борлуулсан уул уурхайн бүтээгдэхүүний 60.2 хувийг металлын хүдэр олборлолтын салбарын бүтээгдэхүүн, 33.7 хувийг нүүрс олборлолтын салбарын бүтээгдэхүүн, 4.2 хувийг газрын тос олборлолтын салбарын бүтээгдэхүүн, 1.8 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.

БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА

Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-ын 40 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа (дотоод худалдаа)-ны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг.

Худалдааны салбарын нийт борлуулалт 2020 оны эхний 11 сард 18.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (8.9%) их наяд төгрөгөөр буурлаа.

Хүснэгт 14. Худалдааны салбарын нийт борлуулалт, тэрбум төгрөг


	2018*		2019*		2020*		2020* I-XI
	XI	I-XI	XI	I-XI	XI	I-XI	2019* I-XI
	тэрбум төгрөг						хувь
Нийт	1 951.1	18 188.9	1 908.6	20 801.5	1 675.5	18 940.5	91.1
Бөөний худалдаа	642.0	6 425.1	689.6	7 545.5	644.9	7 012.1	92.9
Жижиглэн худалдаа	1 309.1	11 763.7	1 219.0	13 256.0	1 030.7	11 928.4	90.0

Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 2020 оны эхний 11 сард 37.0 хувь нь бөөний худалдаа, 63.0 хувь нь жижиглэн худалдааны салбарт ногдож байна.

Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2020 оны эхний 11 сард 12.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 (10.0%) их наяд төгрөгөөр, бөөний худалдааны борлуулалтын орлого 7.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 533.4 (7.1%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Зураг 13. Худалдааны салбарын болон Улаанбаатар хотын худалдааны нийт борлуулалт, жил бүрийн эхний 11 сард, тэрбум төгрөг



Худалдааны салбарын нийт борлуулалтын 83.2 хувь нь Улаанбаатар хотод ногдож байгаа бөгөөд Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалт 2020 оны эхний 11 сард 15.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (10.6%) их наяд төгрөгөөр буурлаа.

ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2020 онд нийт 146 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.9 тэрбум америк доллар, үүнээс экспорт 7.6 тэрбум америк доллар, импорт 5.3 тэрбум америк доллар боллоо.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 876.9 (6.4%) сая америк доллар, үүнээс экспорт 43.3 (0.6%) сая америк доллароор, импорт 833.6 (13.6%) сая америк доллароор тус тус буурчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2020 онд өмнөх оноос 790.3 сая америк доллароор нэмэгдэж, 2.3 тэрбум америк долларын ашигтай байна.

БНХАУ-тай 2020 онд 7.4 тэрбум ам.долларын худалдааг хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 57.5 хувийг эзэлж, манай улсын нийт экспортын дүнгийн 72.5 хувийг, импортын 36.1 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 15. Гадаад худалдааны гол түнш улсууд, 2020 оны жилийн эцсийн байдлаар


Улс	Нийт бараа эргэлт			Экспорт			Импорт		
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Жилийн өсөлтийн хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Жилийн өсөлтийн хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Жилийн өсөлтийн хувь
Дүн	12 870.3	100	-6.4	7 576.3	100	-0.6	5 293.9	100	-13.6
БНХАУ	7 403.8	57.5	-16.3	5 493.6	72.5	-19.1	1 910.2	36.1	-7.3
ОХУ	1 457.2	11.3	-19.0	57.3	0.8	-15.9	1 400.0	26.4	-19.1
БНСУ	416.4	3.2	-30.7	9.7	0.1	-37.6	406.7	7.7	-30.5
АНУ	257.2	2.0	-12.8	21.4	0.3	-22.9	235.8	4.5	-11.7
ХБНГУ	256.2	2.0	-18.8	10.8	0.1	-58.4	245.4	4.6	-15.3
Япон	196.4	1.5	-3.0	11.6	0.2	-13.9	184.8	3.5	-2.2
Сингапур	168.0	1.3	-4.9	151.3	2.0	-2.1	16.8	0.3	-24.6
Их Британи	117.0	0.9	-63.7	84.1	1.1	-71.1	33.0	0.6	6.4
Бусад	2 598.0	20.2	2.2 ¹	1 971.9	26.0	2.9 ¹	911.16	17.2	0.9 ¹

¹ дахин их

Манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт өмнөх оноос 6.4 хувиар буурахад БНХАУ-тай хийгдсэн худалдаа 16.3 хувь, ОХУ-тай хийсэн худалдаа 19.0 хувь, БНСУ-тай хийсэн худалдаа 30.7 хувь, Их Британи улстай хийсэн худалдаа 63.7 хувь буурчээ.

БНХАУ-д экспортолсон бараа бүтээгдэхүүний 36.6 хувийг чулуун нүүрс, 32.4 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Их Британи улсад экспортолсон барааны 57.4 хувийг боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, 35.5 хувийг чулуун нүүрс, Сингапур улсад экспортолсон барааны 39.7 хувийг боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, 54.3 хувийг чулуун нүүрс эзэлж байна.

Зураг 14. Уул уурхайн гаралтай экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн, сая америк доллароор



Нийт экспортын 69.4 хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлж байгаа ба нийт экспорт өмнөх оноос 43.2 сая америк доллароор буурахад зэсийн баяжмалын экспорт 17.9 сая америк доллар, нүүрсний экспорт 952.2 сая америк доллароор буурсан нь нөлөөлсөн байна.

Харин алтны экспорт өнгөрсөн оноос 4.3 дахин нэмэгдэж, 1.8 тэрбум америк долларт хүрсэн байна.

Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Импорт өмнөх оноос 833.6 сая америк доллароор буурахад авто бензиний импорт 82.7 сая америк доллар, дизелийн түлшний импорт 237.0 сая америк доллар, суудлын автомашины импорт 121.4 сая америк доллар, ачааны автомашины импорт 152.1 сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлжээ.

ОХУ-аас импортоор оруулсан барааны 51.8 хувийг нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас импортолсон барааны 59.8 хувийг суудлын автомашин, БНХАУ-аас импортолсон барааны 6.4 хувийг цахилгаан эрчим хүч, 7.8 хувийг ачааны тэрэг, 85.8 хувийг олон нэр төрлийн бага жинтэй, бараа бүтээгдэхүүн эзэлж байна.

Эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл бүтээгдэхүүн, үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нийт экспортын 96.7 хувийг эзэлж байгаа бол импортын 63.3 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон хүнсний бэлэн бүтээгдэхүүний импорт эзэлж байна.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импортыг улсаар авч үзвэл 2020 онд импортолсон нийт өндөгний 98.9 хувийг ОХУ-аас, шувууны махны 84.0 хувийг БНХАУ-аас, цагаан будааны 44.3 хувийг БНХАУ-аас, 35.6 хувийг Вьетнам улсаас, элсэн чихрийн 42.9 хувийг Тайланд улсаас, 28.3 хувийг ОХУ-аас, маргарины 89.7 хувийг ОХУ-аас, нийлэг мяндсан даавууны 97.3 хувийг БНХАУ-аас, авто бензиний 90.0 хувь, дизелийн түлшний 98.9 хувийг ОХУ-аас, нийтийн тээврийн хэрэгслийн 41.6 хувийг БНСУ-аас, суудлын авто машины 81.8 хувийг Япон улсаас, ачааны авто машины 55.4 хувийг БНХАУ-аас тус тус импортолсон байна.

АЧАА ТЭЭВЭР

Хэдийгээр хорио цээрийн дэглэмд буй ч ачаа тээвэрлэлт, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг бууруулахгүй байх нь эдийн засгийн эргэлтийг хэвийн байлгахад чухал үүрэгтэй учир хилийн боомтуудыг хэсэгчлэн нээж, үүний зэрэгцээ БНХАУ-ын эдийн засаг хүлээлтээс хурдан сайжирч байгаа учир уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт сэргэж байна.

Хүснэгт 16. Бүх төрлийн тээврийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2017	2018	2019	2020*
Тээсэн ачаа, сая тонн	54.0	67.8	69.0	60.3
Зорчигчид, сая хүн	216.1	197.0	173.0	126.5
Тээврийн орлого, тэрбум төгрөг	1 422.2	1 754.4	2 003.5	1 474.1

Эх үүсвэр: УСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2020 онд 60.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 8.7 (12.6%) сая тонноор буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврээр тээсэн ачаа 10.4 (25.4%) сая тонноор буурсан нь голлон нөлөөлжээ.

Бүх төрлийн тээврээр 2020 онд 126.5 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оноос 46.5 (26.9%) сая хүнээр буурсан байна. Зорчигчдын тоо буурахад авто тээврээр зорчигчид 44.3 (26.3%) сая хүнээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Авто замын тээвэр:


Авто тээврээр 2020 онд 30.5 сая тонн ачаа, давхардсан тоогоор 124.1 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос тээсэн ачаа 10.4 (25.4%) сая тонн, зорчигчид 44.3 (26.3%) сая хүнээр тус тус буурсан байна.

Ачаа тээврийн бууралтад уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт 6.8 сая тонн буюу 20.2 хувиар, зорчигч тээврийн хувьд нийслэлийн тээврээр зорчигчид (давхардсан тоо) 40.4 (26.5%) сая хүнээр буурсан нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээвэр:

Төмөр замын тээврээр 2020 онд 29.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 1.7 (6.0%) сая тонноор өсжээ. Төмөр замын тээврээр тээсэн ачааны өсөлтөд экспортын ачаа 1.3 (12.7%) сая тонн, дамжин өнгөрөх ачаа 382.5 (9.8%) мянган тонноор тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Зураг 15. Төмөр замын тээврээр тээсэн ачаа, мянган тонн, сараар



Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Төмөр замын тээврээр 2020 онд тээсэн нийт ачаанд уул уурхайн бүтээгдэхүүн 83.3 хувь, барилгын материал 10.0 хувь, хар төмөр 1.5 хувь, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 0.9 хувь, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 0.9 хувь, мод модон материал 0.5 хувь болон бусад бүтээгдэхүүн 2.9 хувийг эзэлж байна.


Төмөр замын тээврээр 2020 онд 2.0 сая хүн (давхардсан тоо) зорчсон нь өмнөх оноос 982.2 (33.3%) мянган хүнээр буурсан байна. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 2020 оны 12 дугаар сард гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдон зорчигч тээвэрлээгүй.

Төмөр замын тээврийн орлого 2020 онд 770.1 тэрбум төгрөг болсон нь өмнөх оноос 61.4 (8.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүн, тухайлбал төмрийн хүдэр, цайрын баяжмалын тээвэрлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын замын тээвэр:

Агаарын тээврээр 2020 онд 2.5 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 3.2 (56.0%) мянган тонноор буурсан байна.

Зураг 16. Агаарын тээврээр тээсэн ачаа, тонн, сараар



Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Агаарын тээврээр 2020 онд дотоодод 73.5 (2.9%) тонн ачаа тээсэн нь өмнөх оноос 9.5 (11.5%) тонноор буурсан байна.

Мөн олон улсад тээсэн ачаа 2.5 (97.1%) мянган тонн болсон нь өмнөх оноос 3.2 (56.7%) мянган тонноор буурчээ.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2020 онд 161.6 (36.1%) мянган хүн болж, өмнөх оноос 1.0 (86.4%) сая хүнээр, агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 онд 139.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 359.0 (72.0%) тэрбум төгрөгөөр түс түс буурсан байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал аж ахуй

Мал тооллогын урьдчилсан дүнгээр 2020 онд улсын хэмжээгээр 67.1 сая толгой мал, үүнээс 4.1 сая адуу, 4.7 сая үхэр, 472.9 мянган тэмээ, 30.0 сая хонь, 27.7 сая ямаа тоологдов. Малын нийт тоо өмнөх оноос 3.9 сая (5.5%) толгойгоор буурсан бөгөөд үүнд малыг зах зээлд нийлүүлэх, мах бэлтгэл нэмэгдсэн нь гол шалтгаан болсон байна.

Хүснэгт 17. Малын тоо, төрлөөр, мянган толгой, жил бүрийн эцэст

	2017	2018	2019	2020*	Өөрчлөлт	
					тоо толгой	хувь
Нийт	66 219.0	66 460.2	70 969.3	67 061.1	- 3 908.2	- 5.5
Адуу	3 939.8	3 940.1	4 214.8	4 092.7	- 122.1	- 2.9
Үхэр	4 388.5	4 380.9	4 753.2	4 731.4	- 21.8	- 0.5
Тэмээ	434.1	459.7	472.4	472.9	0.5	0.1
Хонь	30 109.9	30 554.8	32 267.3	30 045.6	- 2 221.7	- 6.9
Ямаа	27 346.7	27 124.7	29 261.7	27 718.5	- 1 543.1	- 5.3

Мөн өмнөх оноос төллөсөн хээлтэгч 206.9 мянга, бойжсон төл 809.9 мянган толгойгоор буурч, зүй бусаар хорогдсон том мал 946.5 мянган толгойгоор өссөн байна.

Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Нийт мал сүрэгт 2020 оны тооллогын дүнгээр хонь 44.8 хувь, ямаа 41.3 хувь, үхэр 7.1 хувь, адуу

6.1 хувь, тэмээ 0.7 хувийг эзэлж байна.

Хонин толгойд шилжүүлснээр хадлан, бэлчээрийн 100 га талбайд ногдох малын тоо 2020 онд 102 толгой болж, өмнөх оноос 4 толгойгоор буурсан байна. Энэ үзүүлэлт Орхон аймагт 762, Улаанбаатар хотод 566, Дархан-Уул аймагт 386, Архангай аймагт 289, Булган аймагт 238, Сэлэнгэ аймагт 213, Хөвсгөл аймагт 213 болж, улсын дунджаас 111-660 толгойгоор их байна.

Хүснэгт 18. Малчин өрхийн бүлэглэлт, малын тооны бүлгээр, жил бүрийн эцэст

	Малчин өрхийн тоо				Малчин нэг өрхөд ногдох малын тоо			
	2017	2018	2019	2020*	2017	2018	2019	2020*
Бүгд	169 743	169 706	171 605	181 037	352	351	370	332
50 хүртэлх малтай	20 242	20 322	19 780	23 046	26	26	26	27
51-200	52 100	51 394	49 654	58 861	124	124	124	123
201-500	57 776	58 305	58 378	59 777	325	325	327	324
501-999	28 468	29 061	31 669	29 333	681	682	687	682
1000-2000	10 474	9 975	11 404	9 484	1 230	1 227	1 234	1 217
2001-ээс дээш малтай	683	649	720	536	2 521	2 509	2 531	2 509

Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

Мал тооллогын 2020 оны дүнгээр нийт малтай өрхийн 74.8 хувь буюу 181.0 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа малчин өрх байна. Малчин өрхийн тоо өмнөх оноос 9.4 мянга буюу 5.5 хувиар өслөө. Малчин өрхийг малын тоогоор нь бүлэглэж үзэхэд 50 хүртэлх малтай өрх 16.5 хувиар, 51-200 хүртэлх малтай өрх 18.5 хувиар, 201-500 малтай өрх 2.4 хувиар өссөн байхад, 501-999 малтай өрх 7.4 хувиар, 1000-2000 малтай өрх 16.8 хувиар, 2001-ээс дээш малтай өрх 25.6 хувиар буурсан байна.

Газар тариалан

Улсын хэмжээнд 2020 онд нийт 587.9 мянган га талбайд тариалалт хийсэн нь өмнөх оноос 64.8 (12.4%) мянган га-гаар өссөн байна.

Нийт тариалсан талбайн 408.0 (69.4%) мянган га-д үр тариа, 84.5 (14.4%) мянган га-д таримал тэжээл, 19.0 (3.2%) мянган га-д төмс, 10.6 (1.8%) мянган га-д хүнсний ногоо тус тус тариалсан нь өмнөх оноос таримал тэжээл 40.7 (93.0%) мянган га, үр тариа 38.5 (10.4%) мянган га, төмс 4.1 (27.3%) мянган га, хүнсний ногоо 2.1 (25.3%) мянган га-гаар тус тус өссөн байна.

Газар тариалангийн голлох бүтээгдэхүүн үр тариа хэвээр байгаа боловч нийт талбайд эзлэх хувь буурч, газар тариалангийн бусад бүтээгдэхүүн (хүнсний ногоо, тэжээлийн ургамал, техникийн ургамал)-ний нэр төрөл нэмэгдэж байна.

Хүснэгт 19. Тариалсан талбай, ургамлын төрлөөр

	2017	2018	2019	2020	<u>2020</u> <u>2019</u>
	мянган га				хувь
Бүгд	524.3	507.9	523.1	587.9	112.4
Үр тариа	390.9	366.8	369.4	408.0	110.4
Буудай	365.7	342.4	343.5	377.0	109.8
Төмс	15.1	12.9	14.9	19.0	127.3
Хүнсний ногоо	8.4	8.9	8.4	10.6	125.3
Таримал тэжээл	26.2	46.3	43.8	84.5	193.0
Бусад	85.5	75.3	86.5	65.7	76.0

Үр тариа 2020 онд 430.3 мянган тонн, төмс 244.3 мянган тонн, хүнсний ногоо 121.2 мянган тонн, таримал тэжээл 182.1 мянган тонн, техникийн ургамал 22.6 мянган тонныг хураан авч, 1.2 сая тонн хадлан, 42.2 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн байна

Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020.12

ДҮГНЭЛТ

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4.5 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9.4 их наяд төгрөг болж өмнөх оноос 13.6 хувиар буурсан, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 14.0 их наяд төгрөг болж өмнөх оноос 2.3 их наяд төгрөгөөр (19.7%) өсөж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 4.5 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.

Манай улсад Ковид-19 цар тахлын өвчлөл бүртгэгдсэн эхэлсэн 5 дугаар сараас эхлэн аж ахуй нэгж байгууллагын ажилчдын НДШ-ыг “тэглэх”, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэн зэрэг шийдвэрүүд нөлөөлсөн байна.

Тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын санхүүжилтийг эх үүсвэрээр харвал харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлтөөр 2.1 их наяд төгрөгийг, ЗГ-ын гадаад зээлээр 2.7 их наяд төгрөгийг санхүүжүүлж, дотоодын Засгийн газрын бонд болон зээлийн төлбөрт 0.4 их наяд төгрөгийг төлсөн байна.

ЗГ-ын гадаад зээлийн санхүүжилт өмнөх оноос 2.4 дахин өссөн байна.

Банкны систем дэх хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оноос 54.1 хувь өсөв. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 80.9 хувийг эзлэж байгаа ба өмнөх оноос 9.8 хувь буурсан бол чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.7 хувийг эзлэж, өмнөх оноос 10.1 хувь өсөв.

Иргэдийн ипотекийн зээлийн олголт хэвийн үргэлжиж байгаа бөгөөд арилжааны банкнууд болон Монголын Ипотекийн корпорац (МИК)-аас иргэдэд олгосон ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 11 дүгээр сарын эцэст 4.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 2.9 (0.06%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 295.7 (6.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш 2020 оны 12 дугаар сард 2849.55 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар, юаньтай харьцах сарын дундаж ханш 435.64 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар тус тус суларсан бол төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 38.42 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар чангарсан байна.

Инфляцын түвшин 2020 оны 12 дүгээр сард сард 2.3 хувь боллоо. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.9 пунктээр буурсан байна. Инфляцын түвшин буурч байгаа нь эдийн засгийн идэвх суларсныг илтгэж байна.

Дотоодын үйлдвэрлэл 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 16.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 6.7 хувиар буурлаа. Үүнд уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл 8.4 хувиар, боловсруулах үйлдвэрлэл 6.1 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл буурахад нүүрс олборлолт 28.5 хувиар, газрын тос олборлолт 57.0 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудаас Ковид-19 цар тахлын нөлөөнд хамгийн ихээр өтгөж буй ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх онтой

харьцуулахад 39.9 хувь, хувцас үйлдвэрлэл 45.4 хувь, машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл 63.4 хувь тус тус буурсан байна.

Дотоодын жижиглэн худалдаа энэ оны эхний 11 сарын байдлаар 10.0 хувиар буурсан байна. Худалдааны салбарын нийт борлуулалт 2020 оны эхний 11 сард 18.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (8.9%) их наяд төгрөгөөр буурлаа. Энэ оны эхний 11 сард худалдааны салбарын борлуулалтын орлогын 63.0 хувь нь жижиглэн худалдааны салбарт ногдож байгаа ба жижиглэн худалдааны борлуулалтын орлого 11.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 их наяд төгрөгөөр буурсан байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.4% буурлаа. Манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт өмнөх оноос 6.4 хувиар буурахад БНХАУ-тай хийгдсэн худалдаа 16.3 хувь, ОХУ-тай хийсэн худалдаа 19.0 хувь, БНСУ-тай хийсэн худалдаа 30.7 хувь, Их Британи улстай хийсэн худалдаа 63.7 хувь буурчээ.

Манай улс 2020 онд нийт 146 улстай худалдаа хийсэн ч нийт бараа эргэлтийн 57.5 хувийг БНХАУ эзэлж байна. БНХАУ-д хийсэн экспорт нь манай улсын нийт экспортын дүнгийн 72.5 хувийг, импортын 36.1 хувийг бүрдүүлж байна.

Төмөр замын тээврээр тээсэн ачааны 83.3 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна. Эрдэс бүтээгдэхүүний экспортын дийлэнхийг төмөр замаар тээвэрлэдэг. Төмөр замын тээврээр 2020 оны эхний 11 сард 27.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.9 (7.3%) сая тонноор өссөн байна.

Ковид-19 цар тахлаас шалтгаалан Агаарын тээврээр олон улсад зорчигчид өмнөх оноос 86.4 хувь, агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 72.0 хувиар тус тус буурсан байна.

Мал тооллогын урьдчилсан дүнгээр 2020 онд улсын хэмжээгээр 67.1 сая толгой мал тоологдов. Малын нийт тоо өмнөх оноос 3.9 сая (5.5%) толгойгоор буурсан бөгөөд үүнд малыг зах зээлд нийлүүлэх, мах бэлтгэл нэмэгдсэн нь гол шалтгаан болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 2020 онд 2.6 (давхардсан тоогоор) сая хүнд 1.6 их наяд төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгов. Өмнөх оноос нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 194.6 (8.2%) мянгаар, үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 912.5 (2.4 дахин) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэдийн тоо 2020 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар 30.0 мянга болжээ. Шинээр ажил хайж байгаа иргэдийн тоо буурч байгаа бөгөөд энэ нь иргэдийн ажил хайх идэвх суларч байгааг харуулж байна.

Энэ оны эхнээс коронавируст халдвар дэгдсэнтэй холбоотойгоор хөл хорио тогтоон иргэдийг олон нийтийн газраар явахгүй байж, гараа тогтмол угааж, маск зүүхийг зөвлөж байсны нөлөөгөөр ханиад, томуугийн дэгдэлт өнгөрсөн онуудаас эрс багасаж, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2020 онд 836.3 мянга болж, өмнөх оноос 91.0 (9.8%) мянган хүнээр буурсан байна. Монгол Улсад 2020 оны 3-12 дугаар сард коронавирусын нийт 1215 тохиолдол бүртгэгдсэний 830 (68.3%) нь эдгэрсэн байна. Нийт тохиолдлын 399 (32.8%) нь зөөвөрлөгдсөн, 816 (67.2%) нь дотоодод тархсан халдвар байна.